



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№153 /367/

2022.08.29

Цаг үе, үйл явдал

ЯПОН УЛС, МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, СОЛИЛЦООНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙН ТУСГАЙ ҮЗЭСГЭЛЭНГИЙН НЭЭЛТ БОЛЛОО



МОНГОЛ УЛС, ЯПОН УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИАЦАА ТОГТООСНЫ 50 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, СОЛИЛЦООНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙН ТУСГАЙ ҮЗЭСГЭЛЭН

Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ц.Гандорж, БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Монгол цэргийн музейн захирал Д.Ганзориг, Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Элчин сайд Хироюки, Япон Улсын Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе Дэд хурандаа Ирики Ёохей тэргүүтэй зочид төлөөлөгчид оролцлоо.

Өнгөрөгч 8 дугаар сарын 27 өдөр Монгол цэргийн музейд Япон улс, Монгол Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, солилцооны гэрэл зургийн тусгай үзэсгэлэнгийн нээлт боллоо

Нээлтийн ёслолын ажиллагаанд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг,

ЗХЖШ-ын стратегийн төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ц.Гандорж, БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Монгол цэргийн музейн захирал Д.Ганзориг, Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Элчин сайд Хироюки, Япон

Улсын Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе Дэд хурандаа Ирики Ёохей тэргүүтэй зочид төлөөлөгчид оролцлоо. Энэхүү үзэсгэлэнд Монгол, Япон Улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны айлчлалууд, Монгол Улсын Батлан хамгаалахын их сургуулиас Япон Улсын Үндэсний Батлан хамгаалах их сургуульд суралцагч үе үеийн оюутнуудын тухай, цэргийн төв эмнэлгийн хамтын ажиллагаа,

“Зам” сургалт буюу чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр” зэрэг 4 сэдвийн хүрээнд 60 гаруй түүхэн гэрэл зураг, Японд суралцагч Монгол оюутнуудын ёслолын болон өдөр тутмын дүрэмт хувцас, “Зам” сургалтад хамрагдсан инженерүүдийн улс эх орондоо хийж буй томоохон бүтээн байгуулалтын макет зэргийг дэлгэн үзүүлжээ.

МОНГОЛ ЦЭРЭГ ДЭЛХИЙН ДЭЭД АМЖИЛТЫГ ТОГТООЖЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл-2022” цэрэг-спортын цогцолбор тэмцээний хаалтын ёслолын ажиллагааны үеэр монгол цэргийн онцгой амжилт дэлхийн гиннест бүртгэгдсэн тухай баярт мэдээг ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ зарлаж, батламжийг нь Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр гардуулж, баяр хүргэлээ. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн Зенит, артиллерийн батареины сум зөөгч, жолооч ахлагч С.Батцэнгэл 1111 удаа сонс эргэснээр манай гаригийн дээд амжилтыг тогтоож, түүнийг нь Гиннесийн амжилтаар бүртгэсэн батламжийг Монгол Улсад ирүүлснийг нутаг нутгийн сурагчдын өмнө ёслол төгөлдөр ийнхүү гардуулан өгөв. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ахлагч С.Батцэнгэлд Зэвсэгт хүчний

нийт бүрэлдэхүүний нэрийн өмнөөс баяр хүргээд, түүний дасгалжуулагч Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн Сургалтын төвийн дарга, хошууч Н.Ганзориг болон тамирчнаа бэлтгэсэн ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийнханд гүн талархал дэвшүүлсэн юм. Ийнхүү дэлхийн дээд амжилтын эзэн болсон олон улсын хэмжээний мастер, ахлагч С.Батцэнгэл нь сонс эргэлтээс гадна холын зайн гүйлтээр хичээллэж, Монгол Улсын амжилтуудыг тогтоож байсан тэргүүний цэргийн алба хаагч юм. Түүний гаргасан амжилтыг өмнө нь Армян улсын тамирчин 1001 эргэснээр эзэмшиж байжээ.

АХЛАХ ДЭСЛЭГЧ Д.БОЛОР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|------|
| ☀️ 10 | ☁️ 0 |


ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 31 | ☁️ 21 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|-------|-------|
| USD 🇺🇸 | 3.215 | 3.222 |
| EUR 🇪🇺 | 3.215 | 3.245 |
| CNY 🇨🇳 | 467 | 471 |
| RUB 🇷🇺 | 49.80 | 50.20 |
| JPY 🇯🇵 | 23.45 | 23.70 |
| KRW 🇰🇷 | 2.39 | 2.41 |

ЗУРХАЙ



2022.08.29 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 2

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ТАВАН ШАР ХӨХ БАР ӨДӨР

Үс засуулбал:

Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.06-19.41

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал: Мод

Энэ өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг өргөх, гэрээ хэлцлээ буцаахад сайн. Гөлөг тэжээх, золиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу.

Хол газраар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 606,009,778

Эдгэрсэн

Нийт: 581,525,394

Нас барсан

Нийт: 6,488,394

ЭХ ОРНОО БАТЛАН ХАМГААЛЖ БУЙ ЭР ЦЭРГҮҮДЭЭ ЭРГЭВ



Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2021 оны хоёрдугаар ээлж, 2022 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан залуусаа эргэх үйл ажиллагааг хуваарийн дагуу зохион байгууллаа.

Иргэд олон нийт, хүүхэд залууст Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлан таниулах, монгол цэргийн уламжлалаа хүндэтгэн бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой энэхүү арга хэмжээг эр цэргүүд, ээж, аав, гэр бүл нь талархалтай хүлээж авлаа.

Зэвсэг хүчний 326 дугаар ангийн Зенитийн артиллерийн дивизионы хугацаат цэргийн алба хаагчдын 50 гаруй хувийг Сүхбаатар дүүргээс татагдсан цэргүүд эзэлж байгаа. Тус ангид алба хааж буй залуусаа дүүргийн Засаг дарга Х.Болормаа ажил хариуцсан мэргэжилтнүүдийн хамт эргэж, албаны нөхцөл байдалтай танилцсан юм.

Хурандаа Г.Отгонбаяр захирагчтай тус ангид алба хааж буй залуус албаа нэр төртэй хааж, ангиас зохион байгуулж үйл ажиллагаа, дугуйлангуудад идэвхтэй хамрагдаж өөрсдийгөө нээн хөгжүүлж байна. Тухайлбал, ангийн захирагчийн тушаалаар



байгуулсан үлээвэр найрал хөгжмийн салаанд Сүхбаатар дүүргийн олонцэргүүд хамрагдаж анхны бие даасан тоглолт зохион байгуулж, ар гэр, ангийн нийт бие

бүрэлдэхүүндээ сонирхуулжээ. Тус анги 90 гаруй албан хаагчаа В,С ангиллын жолооны сургалтад хамруулсны 46 нь Сүхбаатар дүүргийн залуус байна. Тэд

жолооч мэргэжилтэй халагдана.

Мөн алба хаагчдын сургалт, өдөр тутмын мэдээг ар гэрт нь өгдөг, санал, хүсэлтийг хүлээн авдаг фейбүүкийн хаалттай группийг хөтөлж байгаа нь талархал хүлээсэн ажил болжээ.

Хуваарийн дагуу 2022.08.11-2022.08.15-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын дарга Н.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг Завхан аймгийн Тэс сумын нутагт байрлах, хурандаа Б.Уламжаргал захирагчтай Хилийн цэргийн 277, Увс аймгийн Баруунтуруун сумын нутаг дахь хурандаа Д.Ганхуяг захирагчтай Хилийн цэргийн 0311 дүгээр ангиудад алба хааж буй залуусаа эргэсэн юм.

Эх орны дархан хилээ хамгаалж буй залуус маань цэргийн эрдэмд шамдан суралцаж, албаа сэтгэл дүүрэн, нэр төртэй хааж байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хугацаат цэргийн алба хаагчдынхаа нөхцөл байдалтай танилцахын зэрэгцээ тэдэнд Засаг даргын гарын бэлэг, дурсгалын зүйлс, анги байгууллагад эрүүл мэндийг дэмжих, халдвараас хамгаалах хэрэгсэл, компьютер, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн юм.

